11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,732,841,874	2,478,237,414.16	1,821,473,801.13	6,032,553,089.29
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			10,027,011.61	10,027,011.61
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,732,841,874	2,478,237,414.16	1,831,500,812.74	6,042,580,100.90
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		-10,027,011.61		-10,027,011.61
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Өмчид гарсан өөрчлөлт				
18	Зарласан ногдол ашиг				
19	Тайлант үеийн үр дүн			1,147,432,124.49	1,147,432,124.49
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,732,841,874	2,468,210,402.55	2,978,932,937.23	7,179,985,213.78

**2.5. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,599,108,000.00</b>	<b>2,375,487,149.38</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,311,246,600.00</b>	<b>2,261,740,949.38</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,265,129,700.00</b>	<b>2,217,063,049.38</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,467,895,200.00</b>	<b>1,453,418,429.98</b>
210101	Үндсэн цалин	1,127,620,200.00	1,122,250,526.00
210102	Нэмэгдэл	174,216,200.00	174,159,324.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,808,000.00	5,730,000.00
210104	Урамшуулал	95,675,700.00	87,826,444.57
210105	Гэрээт ажлын хөлс	64,575,100.00	63,452,135.31
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>198,258,000.00</b>	<b>191,998,614.12</b>
210201	Тэтгэврийн даатгал	139,508,300.00	136,211,285.16
210202	Тэтгэмжийн даатгал	14,687,600.00	13,985,050.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,749,600.00	11,111,141.42
210204	Ажилгүйдлийн даатгал	2,937,700.00	2,686,483.03
210205	Эрүүл мэндийн даатгал	29,374,800.00	28,004,653.82
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>318,747,300.00</b>	<b>297,166,578.28</b>
210301	Гэрэл, цахилгаан	14,845,600.00	10,725,489.38
210302	Түлш, халаалт	302,710,400.00	286,085,088.90
210303	Цэвэр, бохир ус	1,191,300.00	356,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>100,967,900.00</b>	<b>100,537,165.00</b>
210401	Бичиг хэрэг	6,190,500.00	6,327,350.00
210402	Тээвэр, шатахуун	59,183,000.00	58,793,675.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,831,100.00	3,706,390.00
210404	Ном, хэвлэл	856,100.00	804,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,855,900.00	6,855,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,051,300.00	24,049,850.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>91,043,000.00</b>	<b>91,040,720.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	29,190,000.00	29,189,980.00
210502	Хоол, хүнс	56,006,900.00	56,004,740.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,846,100.00	5,846,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>34,120,900.00</b>	<b>33,908,960.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,294,500.00	14,083,600.00
210602	Тавилга	4,145,000.00	4,144,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	583,300.00	583,300.00
210604	Урсгал засвар	15,098,100.00	15,097,260.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,693,300.00</b>	<b>7,371,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,693,300.00	7,371,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,284,700.00</b>	<b>6,275,679.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,400,400.00	1,653,830.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,886,400.00	1,814,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	274,000.00	274,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	459,000.00	274,135.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154,000.00	148,414.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,629,000.00	1,629,000.00
210807	Газрын төлбөр	481,900.00	481,900.00

Зүүнхангай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>36,119,400.00</b>	<b>35,345,703.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,823,300.00	26,049,703.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,296,100.00	9,296,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>46,116,900.00</b>	<b>44,677,900.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>46,116,900.00</b>	<b>44,677,900.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,539,300.00	37,100,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,577,600.00	7,577,600.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>170,577,500.00</b>	<b>113,746,200.00</b>
223001	Бусад хөрөнгө	170,577,500.00	113,746,200.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>117,283,900.00</b>	<b>0.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	117,283,900.00	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,599,108,000.00</b>	<b>2,459,660,947.38</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,591,935,200.00</b>	<b>1,580,959,336.53</b>
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,453,611,500.00	1,442,635,732.53
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	138,323,700.00	138,323,604.00
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>819,779,700.00</b>	<b>790,690,707.85</b>
320001	Орон нутгийн төсвөөс	819,779,700.00	790,690,707.85
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>23,171,200.00</b>	<b>19,049,260.00</b>
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	23,171,200.00	19,049,260.00
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>164,221,900.00</b>	<b>68,961,643.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	121,950,000.00	68,961,643.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	0.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	32,271,900.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	32,271,976.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	115,946,094.00
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>895.00</b>	<b>895.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>6.00</b>	<b>6.00</b>
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>129.00</b>	<b>129.00</b>
620001	Удирдах ажилтан	12.00	12.00
620002	Гүйцэтгэх ажилтан	78.00	78.00
620003	Үйлчлэх ажилтан	27.00	27.00
620004	Гэрээт ажилтан	12.00	12.00

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>145,398,330.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>145,398,330.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>55,118,330.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>13,866,654.00</b>
210101	Үндсэн цалин	13,866,654.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,856,646.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	764,750.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,091,896.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>340,000.00</b>
210302	Түлш халаалт	340,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,825,140.00</b>
210401	Бичиг хэрэг	1,176,180.00
210402	Тээвэр, шатахуун	2,803,460.00
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	160,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэчдийн устгал, ариутгал	580,000.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	4,105,500.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>18,924,700.00</b>
210501	Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл	16,102,600.00
210502	Хоол хүнс	2,822,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,200,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,700,000.00
210604	Урсгал засвар	4,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр</b>	<b>1,085,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	835,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,020,190.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,882,190.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,138,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>60,280,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>60,280,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	60,280,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>30,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>30,000,000.00</b>
223001	Бусад хөрөнгө	30,000,000.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>145,433,332.00</b>
<b>31</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>145,433,332.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47,579,332.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	97,854,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зүүнхангай сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Нанжидмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнхангай сумын Засаг даргын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Шалгагдагч этгээд, түүний орчин ба дотоод хяналт

Зүүнхангай сумын Засаг дарга нь “Оновчтой бодлого зохицуулалтаар ард иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлж, орон нутгаа хөгжүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Хөдөө аж ахуйн салбарыг эрчимжүүлэн хөгжүүлэх
- Байгаль хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх
- Орон нутагт дэд бүтэц, бизнесийн орчныг сайжруулах
- Байгалийн баялаг, орон нутгийн нөөц боломжид тулгуурлан жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх
- Төрийн үйлчилгээний ил тод байдлыг ханган чанар хүртээмжийг дээшлүүлэх
- Төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

Шалгагдагч этгээдийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд

хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Зүүнхангай сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн нэгтгэсэн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнхангай сумын Засаг даргын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 35.3 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөхгүйгээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,537.4 сая төгрөгийн 1 хувь буюу 35.4 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 28.3 сая төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Зүүнхангай сумын Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,136.4 сая төгрөгөөр буюу 18.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая. төгрөгөөр /		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Эргэлтийн хөрөнгийн дүн	550.2	814.4	264.2
Мөнгөн хөрөнгө	78.5	237.4	158.9
Авлага	272.3	316.6	44.3
Урьдчилгаа	0.0	0.0	0.00
Бараа материал	199.5	260.4	60.9
Үндсэн хөрөнгө	5,501.6	6,373.8	872.2
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>6,051.9</b>	<b>7,188.3</b>	<b>1,136.4</b>
Өр төлбөр	19.3	8.3	-11.0
Засгийн газрын хувь оролцоо	<b>6,032.5</b>	<b>7,179.9</b>	<b>1,147.4</b>
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>6,051.9</b>	<b>7,188.3</b>	<b>1,136.4</b>

Эх сурвалж: Зүүнхангай сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан

**3.5.1 Мөнгөн хөрөнгө**

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 237.4 сая төгрөг болж 158.9 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлого, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эрүүл мэндийн төвийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

**3.5.2 Авлага**

Авлага дансны үлдэгдэл 316.6 сая төгрөг болж 44.3 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн төвийн авлага нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай Сум хөгжүүлэх сангийн 12.0 сая, Орон нутгийн хөгжлийн сангийн 60.0 сая, нийт 72.0 сая төгрөгийн авлага байна.

Аудитын илрүүлэлт:

**Зүүнхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал:**

-Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2 дахь заалт "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасныг зөрчин өмнөх оны 0.7 сая төгрөгийн НДШ авлага тусгаагүй зөрчилд авлага, өр төлбөрийг бүрэн тайлагнах зөвлөмж өглөө.

**3.5.3 Бараа материал**

Бараа материалын дансны үлдэгдэл 260.4 сая төгрөг болж 60.9 сая төгрөгөөр өссөн нь Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

**3.5.4 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,373.8 сая төгрөг болж 872.2 сая төгрөгөөр өссөн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 24.5 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 1,167.2 сая, нийт 1,191.7 сая төгрөгөөр нэмэгдэж, 158.8 сая төгрөгийн хөрөнгө акталж хассанаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,179.9 сая төгрөг болж 1,147.4 сая төгрөгөөр буюу 19 хувиар өссөн байна

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,341.3 сая төгрөгөөр буюу 38.6 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 285.9 сая төгрөгөөр буюу 8.7 хувиар өссөн байна.

### 3.5.5 Орлогын данс

Тайлант онд татварын орлого 149.8 сая, татварын бус орлого 32.5 сая, тусламж санхүүжилтийн орлого 3,357.8 сая, нийт 3,540.1 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

#### Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төв:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх" гэж заасныг зөрчин нь нэмэлт санхүүжилтийн 32.2 мянган төгрөгийн орлогыг дутуу тайлагнасныг залрууллаа.

### 3.5.6 Зардлын данс

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчид 28.7 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

#### Аудитын илрүүлэлт:

##### Зүүнхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас хагас өнчин хүүхдүүдэд бэлэг өгөхөд 0.2 сая, цагдаагийн кабоны интернэтийн төлбөрт 0.3 сая, нийт 0.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгсөн.

##### Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах хөрөнгийн шийдвэр тодорхой бус, зарцуулсан шатахууны ажлын тайлангүй зөрчилд:

-Хууль зүйн сайд, Сангийн сайдын 152 тоот хамтарсан тушаалаар баталсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам"-ын 2 дахь хэсэгт тусгагдсан зардлыг санхүүжүүлэх,

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд захиран зарцуулах хөрөнгийн шийдвэрийг тодорхой төсөвтэй гаргаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулсан шатахууны ажлын тайлан гаргаж байх зөвлөмж өглөө.

##### Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төв:

-Эрүүл мэндийн төвийн дарга нь Эрүүл мэндийн сайдын А/496 дугаар тушаалаар олгосон төрийн албан хаагчийн мөнгөн урамшуулал болон Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 377/А99 дугаар тушаалаар баталсан цалин хөлс, урамшуулалтай давхардуулан эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр өөрөө өөртөө шийдвэр гарган 3,000.0 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмж авсан зөрчилд албан шаардлага өглөө

-Төрийн албан хаагчийн мөнгөн урамшуулал болон ковид-19 цар тахалтай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/496 дугаар тушаалаар олгосон мөнгөн тэтгэмжтэй давхардуулан эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр ажилтнуудад 25,200.0 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон зөрчилд Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 64/А/268 дугаар тушаалын 3.7 "Энэхүү журмын 3.1-3.5-д заасан санхүүжилтэд эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, эм, урвалж бодисын зэрэг шууд зардал болон холбогдох шууд бус зардал багтана" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өглөө.

## 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Зүүнхангай сумын 2021 оны төсвийг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2/05 дугаар тогтоолоор 2,529.8 сая төгрөгөөр баталж 2021 оны 08 дугаар сарын

10-ны өдрийн 5/02 дугаар тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 69.3 сая төгрөгөөр өсгөж 2,599.1 сая төгрөгөөр баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,599.1 сая төгрөгийн төсөв баталснаас 1,591.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 819.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 23.2 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 164.2 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас, санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,580.9 сая, орон нутгийн төсвөөс 790.7 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 19.0 сая, төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 68.9 сая, нийт 2,459.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,261.7 сая төгрөгийг зарцуулж улсын төсөвт 6.5 сая, орон нутгийн төсөвт 34.0 сая, нийт 40.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,375.5 сая төгрөг буюу 91.4 хувьтай байгаа нь харилцах дансны үлдэгдэл 115.9 сая, зардлын хэмнэлт 40.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь нөлөөлсөн байна.

Зүүнхангай сумын ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн сумын 2021 оны тодотгосон төсөв батлах тухай 5/02 дугаар тогтоолд зааснаар Зүүнхангай сумын Засаг дарга тайлант онд 102.8 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 171.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 167.2 хувиар биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 47.5 сая, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс ирсэн хандив 7.3 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 90.5 сая, нийт 145.4 төгрөгийн орлогыг бүрдүүлж 145.3 сая төгрөгийг зарцуулж 0.03 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Зүүнхангай сумын Засаг даргын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх аудитаар илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахгаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс хугацаандаа оруулсан 141, хугацаа хоцроож 14 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Эрүүл мэндийн төвийн Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлбөрт үйлчилгээний орлогын авлага 98.2 сая төгрөг байна. Тухайн авлагын дагуу 2022 оны 1 дүгээр сард санхүүжилтийг олгосон байна.

Засаг даргын тамгын газар нь Аймгийн Засаг даргын 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн А/43 дугаар захирамжаар сумдын Засаг даргын тамгын газрын, багийн бүтэц орон тоог батлахдаа гэрээт ажилтны орон тоог батлаагүй байна. Дараагийн аудитаар тухайн авлагын зарцуулалтыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

#### **3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар**

Зүүнхангай сумын Засаг даргын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 3 тусгай сан, нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 санг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 5 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 1 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 61.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 32.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, 3.5 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 25.3 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Засаг даргын тамгын газар	0	0	0	0	0	0	0	0	0	0
2	Эрүүл мэндийн төв	3	60.4	1	32.2			1	3.0	1	25.2
3	Ерөнхий боловсролын сургууль	0	0	0	0	0	0	0	0	0	0
4	Соёлын төв	0	0	0	0	0	0	0	0	0	0
5	Цэцэрлэг										
6	ИТХ	4	0.6	0	0	0	0	1	0.5	3	0.1
7	<b>Нийт</b>	<b>7</b>	<b>61.0</b>	<b>1</b>	<b>32.2</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>3.5</b>	<b>4</b>	<b>25.3</b>

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Зүүнхангай сумын Засаг дарга	0	0.0								
	<b>НИЙТ</b>	<b>0</b>	<b>0.0</b>								


Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР  /А.НАНЖИДМАА/

2022 оны 03 сарын 21-ний өдөр